

**ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-15

1.Хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн талаарх танилцуулга 3-10

2.Дэд хорооны дарга, гишүүд Цагдан хорих 461 дүгээр ангид ажилласан талаарх мэдээлэл 10-15

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хүний эрхийн дэд хорооны
05 дугаар сарын 25-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний эрхийн дэд хорооны дарга Х.Баасанжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 35 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэболд;
Чөлөөтэй: О.Номинчимэг, Х.Тэмүүжин.

**Нэг.Хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн
хэлэлцүүлгийн талаарх танилцуулга**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Хунан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг, Хяналт, шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш, зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Хэлэлцүүлгийн талаарх танилцуулгыг Хүний эрхийн дэд хорооны дарга Х.Баасанжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Хүний эрхийн дэд хорооны дарга Х.Баасанжаргал хариулж, тайлбар хийв.

Х.Баасанжаргал: “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Хүний эрхийн дэд хорооноос гарсан холбогдох санал, дүгнэлтийг тусгуулах талаар Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	1
Бүгд:	6

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүд хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн талаарх танилцуулгыг сонсов.

Уг асуудлыг 12 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Дэд хорооны дарга, гишүүд Цагдан хорих 461 дүгээр ангид ажилласан талаарх мэдээлэл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн С.Дондов оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг, Хяналт, шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш, зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Мэдээллийг Хүний эрхийн дэд хорооны дарга Х.Баасанжаргал танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Хүний эрхийн дэд хорооны дарга Х.Баасанжаргал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Дэд хорооны дарга, гишүүд Цагдан хорих 461 дүгээр ангид ажилласан талаарх мэдээллийг сонсов.

Дэд хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Уг асуудлыг 13 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 36 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА

Х.БААСАНЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
12 цаг 35 минут.

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Баасанжаргал: Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанд Хүрэлбаатарын Баасанжаргал, Баярмагнай Баярбаатар, Жудгийн Баярмаа, Пүрэвжавын Сайнзориг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг гэсэн гишүүдийн ирцтэйгээр ирц 54.5 хувийн ирцтэй байгаа учраас өнөөдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 25 дахь илтгэлд тусгагдсан хүүхэд хамгааллын тогтолцоонд тулгамдаж байгаа зарим асуудал сэдвийн хүрээнд нээлттэй хэлэлцүүлгийг орон нутагт зохион байгуулсан талаарх танилцуулга хийнэ.

Энэ танилцуулгатай холбоотой Хууль зүйн байнгын хороонд бас тогтоолын төсөлд өгөх санал дээр санал хураалт явуулна.

2 дугаарт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид бас бас очиж ажиллаж танилцсан. Тэгээд энэ талаарх бас танилцуулах мэдээллийг бас гишүүдэд хүргэнэ ээ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу?

Саналтай гишүүд байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хамгийн эхний асуудалтай хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлэгтэй холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Жаргалсайханы Хунан гишүүн өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Танилцуулга, мэдээллийг би өөрөө хүргэе. Тэгээд танилцуулга, мэдээллийн явцад бас би Өвөрхангай аймгийн хүүхдүүдийн дуу хоолойг бас энэ Хүний эрхийн дэд хороон дээр бид нар сонсоно. Яг энэ хүүхдүүдийн саналтай холбоотой, мөн Хүний эрхийн Үндэсний Комиссын хэлэлцүүлэгтэй холбоотой хэд хэдэн саналыг хууль Хууль зүйн байнгын хороонд уламжилж Хууль зүйн байнгын хорооноос батлагдах Их Хурлын чуулган дээр батлагдах хүний эрхийн 25 дугаар илтгэлтэй холбоотой саналыг дээр бас бид нар саналаа хэлнэ ээ гэж бодож байна.

Дэд хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны дарга, гишүүд 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Өвөрхангай аймагт ажиллаж Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний

байдлын талаарх 25 дахь илтгэлийн зарим хэсгийг орон нутагт хүүхдийн оролцоотой хэлэлцүүлж, тэдний нийгмийн амьдралдаа оролцох эрхийг ханган Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Хүний эрхийн дэд хорооны үйл ажиллагааг хүүхэд өөрт хамаарах асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт, дүгнэлт өгөхөд оролцох, үзэл бодол, саналаа илэрхийлэх явдлыг дэмжих зорилгод чиглүүлэн ажиллалаа.

Өвөрхангай аймаг нь хүүхдийн эрх хамгааллын чиглэлд орон нутагтаа анхдагч сайн туршлагауудыг бий болгосон онцлогтой. Тухайлбал, сум бүрд хүүхдийн асуудал хариуцсан ажилтны орон тоог анх бий болгох санаачилгыг гаргаж, хүүхдийн тусламжийн утас ажиллуулж эхэлж байсан. Мөн 2017 онд өвөл, хаврын морин уралдааныг хориглосон шийдвэрийг анх гаргаж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлсэн. Улирал бүр хүүхдийн оролцоог хангасан тогтолцоог бүрдүүлж буй зэрэг сайн туршлагыг бол дурдах нь зүйтэй.

Ийм учраас эдгээр сайн туршлага дээр үндэслэн энэ удаагийн нээлттэй хэлэлцүүлгийг Хүний эрхийн дэд хороо анх удаагаа орон нутагт Өвөрхангай аймагт бол хүүхдүүдийн оролцоотой зохион байгууллаа.

Уг ажлын хүрээнд “Дэлхийн зөн” олон улсын байгууллага, бусад төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран зорилтот бүлгийн 2 өрхтэй уулзаж, ийнхүү төрийн үйлчилгээний анхан шатан дээрх үйлчилгээтэй бол газар дээр нь танилцсан.

2 дугаарт, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн эрхийн хэрэгжилтийг шалгах зорилгоор Өвөрхангай аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэдэх түр хамгаалах байрны үйл ажиллагаа, орчин нөхцөлтэй танилцсан.

Мөн Өвөрхангай аймаг дахь сум дундын анхан шатын шүүх, аймгийн эрүү, иргэний давж заалдах шатын шүүх, аймгийн прокурорын газар, өмгөөлөгчид, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчидтай уулзалт зохион байгуулж, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаарх мэдээллийг өгч, хэлэлцүүлгийг мөн зохион байгуулсан.

4 дүгээрт, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлд тусгагдсан хүүхэд хамгааллын тогтолцоонд тулгамдаж байгаа зарим асуудлын сэдвийн хүрээнд хүүхэд үүрэг хүлээгчдийн төлөөллийн оролцоотой нээлттэй хэлэлцүүлгийг бол тус тус зохион байгуулсан.

Хэлэлцүүлгийг нээж Монгол Улсын Их Хурлын дарга Бямбацогт хэлсэн үгэндээ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлээр өгсөн санал, зөвлөмж Улсын Их Хурлын холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын асуудлыг орон нутагт бодитой хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатайг онцолсон.

Хэлэлцүүлэгт ерөнхий боловсролын сургуулийн сурагчид оролцож, өөрсдийн эрхийн хэрэгжилтэд тулгамдаж байгаа асуудлыг хөндөн тавьсан. Эдгээр асуудлуудыг тоймлож та бүхэндээ хүргэнэ. Үүний өмнө бас яг тухайн хэлэлцүүлэгт

оролцсон хүүхдүүдийн төлөөллийг бас би та бүхэнд энэ дэлгэцэд дуу хоолойг нь хүргэх нь зүйтэй байх аа гэж бодож байна. Ингээд дэлгэцийг бичлэгээ явуулъя.

Тэгээд хүүхдүүдийнхээ дуу хоолойг бас зорьж очиж сонссон учраас Хууль зүйн, Хүний эрхийн дэд хороон дээрээ сонсох нь зүйтэй. Яг энэ хүүхдүүдийн хэлсэн саналуудыг би товчхон тоймлоод хүргэе. Хамгийн гол нь хүүхдүүдийн хэлж байсан санал дотроос хамгийн олон санал нь бол гэрээс сургууль хүрэх зам, сургуулийн орчны аюулгүй байдал хангалтгүй байна. Тэр дундаа эзэнгүй нохойны асуудлыг хөнддөг. Гэвч эзэнгүй нохойны тухай томчууд насанд хүрэгчдэд энэ саналыг хэлэхээр хүүхдүүдийн нүдэн дээр нохойг буудчихдаг ийм асуудал гарсан байна. Тийм учраас зохион байгуулалттай хүнлэг хийгээч ээ гэдэг хүсэлтийг хүүхдүүдээс гаргасан.

Мөн гэрэл, гэрэлтүүлэггүй орчны тухай, дуусаагүй барилга, байгууламж гээд эдгээр орчны аюулгүй байдлыг бол хангаагүй байдал нь хүүхдийн зам, гэрээс сургууль хүрэх замыг бол аюултай нөхцөл байдалд оруулаад байна аа гэдэг ийм саналыг хүргэсэн.

2 дугаарт, замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдаагүй. Тэр дундаа гэрлэн дохионы зохицуулалтыг маш оновчгүй байна гэж хүүхдүүд хэлсэн. Явган хүний зам ассан хэр нь баруун тийшээ эргэдэг уулзвар нь дандаа гэрэл нь асаалттай байдаг. Тэндээс дандаа хүүхдүүд гэрээсээ сургууль руугаа явах ийм замд нь таардаг. Тэгэхээр энэ гэрлэн дохиог яг хүүхдийн замд ийм ээлтэй, оновчтой зохион байгуулаач ээ гэдэг ийм хүсэлтийг гаргасан.

Номын сангийн хүртээмж бага, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх орчин хомс байна аа гэдэг. Мөн хамгийн сонирхолтой бас миний хувьд, хувь хүний хувьд анхаарал татсан нэг санал нь тэмцээн, уралдааны зохион байгуулалт, шалгаруулалт өөрөө маш тодорхойгүй. Насанд хүрэгчид шударга бус хандаж байгаа нь олон тэмцээн уралдаан дээр харагддаг аа гэдэг энэ талаар бол хүүхдэд хэлсэн.

Үе тэнгийн дээрэлхэлд хүүхдийн гаргасан аливаа зөрчилд авч байгаа хариу арга хэмжээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь хангалтгүй байна. Хүүхдэд дандаа хариуцлага оногдуулах тухай томчууд яриад байна. Харин тэр алдаа гаргасан хүүхдийг засаж авах, залруулах, сургалтад хамруулах талаар ерөөсөө мэдээлэл байхгүй байна. Үүнийгээ бас томчуудыг анхаараач ээ гэдэг ийм хүсэлтийг хэллээ.

Хүүхдийг оролцуулж тэдний дуу хоолойг сонсдог боловч хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгддэггүй талаар сая бас хамгийн сүүлд хүүхэд хэллээ. Эдгээр саналыг бол Өвөрхангай аймгийн хүүхдүүд илэрхийлснийг Хүний эрхийн дэд хорооны хуралдаан дээр албан ёсоор танилцуулах нь зүйтэй гэж үзлээ.

Ингээд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд мөн холбогдох мэдээллүүдээ хүргэсэн. Ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл болоод аймаг, орон нутгийн илтгэлүүдийг нөхцөл байдалтай танилцаад дараах ийм 3 саналыг, дараах 4 саналыг Хүний эрхийн дэд хорооны зүгээс Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх ийм саналыг та бүхэнд танилцуулж байна.

1 дүгээрт, Монгол Улсын Ерөнхий сайд жил бүр аймаг, нийслэлийн Засаг дарга нартай гэрээ байгуулдаг. Энэ гэрээнд дараах 3 нөхцөлийг тусгах саналтай байгаа.

1 дүгээрт, хүүхдийн оролцоонд үндэслэн хүүхэд хамгааллынхаа төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог бий болгох, эргэх холбоотой байх механизмыг тогтвортой бий болгох талаар аймаг, орон нутгийн удирдлагуудад гэрээн дээрээ бас үүрэг болгож оруулаач ээ. Энэ нь бол хүүхдийн нийгмийн оролцоог бол хангахад маш том түлхэц болно оо гэж байгаа юм.

2 дугаарт, хүүхдийн эрхийн асуудлыг зөвхөн нийгмийн хамгааллын салбарын хүрээнд бус орон нутгийн хөгжлийн бодлогын салшгүй хэсэг болох ач холбогдлыг нь харгалзан үзэж, хүүхдийн оролцоонд үндэслээд хүүхэд орчны үнэлгээг тогтмол хийж, орчны аюулгүй байдлыг хангаж ажиллаач ээ. Энэ орчны үнэлгээг томчууд өөрсдөө хийчхээд байна. Энийг хүүхдүүдээр өөрсдөөр нь хийлгээд хаана хамгийн аюултай цэг, бүс байгаа юм бэ гэдгийг бид нар хамгийн сайн хэлнэ ээ. Үүнийг маань санал болгож авч үзэж байгаач ээ гэдэг ийм хүсэлтийг илэрхийлсэн.

Тийм учраас орчны үнэлгээг аймаг, орон нутгийн удирдлагууд хийхдээ хүүхдийн оролцоотой хийж, төлөвлөгөө гаргаж, үе шаттайгаар хүүхдүүдэд танилцуулах нь зүйтэй гэж үзэж байгаа.

3 дугаарт, иргэний нийгмийн орон зайг бий болгох, хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар тусгаж, гэрээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт болгох гэсэн эдгээр 3 үзүүлэлтийг аймаг, нийслэлийн удирдлагуудтай хийдэг гэрээн дээр заалт болгож тусга аа гэдэг ийм саналыг оруулж байгаа.

2 дугаарт, хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа нийгмийн ажилтан, хүний нөөцийн сэтгэцийн эрүүл мэнд, ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх байна. Өндөр ачаалал, эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа нийгмийн ажилтан, алба хаагчдад чиглэсэн сэтгэл зүйн үйлчилгээ, чадавхжуулах сургалт, зан үйлийн өөрчлөлтийн хөтөлбөрийг бол яг улсын төсөвт тодорхой тусгаж хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үүнтэй холбоотой мэдээлэл маш хангалтгүй байгаад байна. Энэ ажлыг ерөөсөө тогтмол үе шаттайгаар хийж хэвшүүлээгүй байна аа гэдэг ийм дүгнэлтэд хүрлээ.

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргатай байгуулдаг хамтран ажиллах гэрээ, үр дүнгийн шалгуур, үзүүлэлтүүдэд хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр бодит үр дүн гаргасан эсэхийг тус тусгай шалгуур болгон оруулах нь зүйтэй. Ингэснээр хүүхдийн асуудал бодлогын түвшинд илүү хариуцлагатай хэмжигдэхүйц байдлаар хэрэгжих нөхцөл бүрдэнэ гэж үзлээ.

Дэд хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар хэлэлцэхдээ илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар гаргах Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Хүний эрхийн дэд хорооноос хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн үр дүнгийн холбогдох хэсгийг тусгах саналыг та бүхэнд танилцууллаа.

Анхаарал хандуулсан баярлалаа гэж.

Ингээд танилцуулгатай холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Энийг энэ дээрээ санал хураах юм хэдүүлээ. Тэгээд Хууль зүйн байнгын хороо руу хүргүүлнэ. Пүрэвжавын Сайнзориг гишүүнээр тасалбар болголоо. Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Төсөлтэй холбогдуулаад энийг чинь хэрэгжүүлэхэд чинь бас тодорхой хэмжээний зардал гарах байх тээ? Тийм тооцоолол хийсэн юм байдаг юм болов уу? Төсөв дээр тусгахаар чинь энэ оруулаад байгаа санал маань өөрөө тодорхой хэмжээний цаад талдаа ямар зардалтай юм бэ? Тэр талын асуудлыг энэ төсөв дээр тооцоолол хийсэн юм уу л гэж асуух гэсэн юм.

Х.Баасанжаргал: Яг энэ 2 дахь заалт буюу энэ хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа нийгмийн ажилтан хүний нөөцийн сэтгэцийн эрүүл мэнд, ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх бодлого гээд энэ дээр бол тодорхой хэмжээний зардал гарах байх. Үүнийгээ бол бас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам төсөвлөөд 27 оны төсөв дээр оруулж ирэх гэдэг ийм байдлаар бол эхний ээлжид өгч байгаа.

Үүнийг яагаад оруулж байгаа вэ гэвэл 2024 онд Хүүхэд хамгааллын хууль батлагдаад бүх сумд хүүхдийн ажилтантай болсон. Гэхдээ түрүүчээсээ бараг эргээд 20-30 хувь нь эргээд бүгдээрээ ажлаасаа гарах тал руугаа болчихлоо. Тэгэхээр бид нар энэ том тогтолцоог 24 онд угсраад эргээд буцаад энэ тогтолцоо нурах аюулд ойрхон байна гэсэн үг. Тэгэхээр үүнээс өмнө энэ хүмүүсийг хамгаалах, ялангуяа сэтгэцийн эрүүл мэндийн асуудал дээр нь маш өндөр эрсдэлтэй ажилладаг маш хүнд ажлыг хийдэг эдгээр хүмүүсийнхээ энэ зан үйлийн сургалтын асуудлыг бол анхаарах хэрэгтэй. Хэрвээ манай хаврын чуулганаар бид нар нийгмийн ажилтны хуулийг батлах юм бол энэ маань бас өөрөө системтэйгээр нэг алхам бол шийдэгдэх ийм боломж бүрдэнэ ээ гэж харж байгаа юм.

2 дугаарт, хүүхдүүдийн саяын гаргасан саналтай холбоотой Өвөрхангай аймаг өөрсдөө аймгийнхаа хэмжээнд төлөвлөгөөгөө гаргаад яг эдгээр хүүхдүүдийн гаргасан асуудлуудыг шийдвэрлэх бүрэн боломжтой. Аймаг өөрийнхөө орон нутгийнхаа нөөц бололцоогоор шийдвэрлэх бүрэн боломжтой. Үүнийгээ албан ёсоор танилцуулаад Хүний эрхийн дэд хороонд их хүргүүлье ээ гэсэн ийм юутай байгаа гэж байгаа юм.

Сайнзориг гишүүний микрофоныг.

П.Сайнзориг: Зөвхөн Өвөрхангай аймгийн хүүхдүүдийн санал, хүсэлт гэхээсээ илүүтэй ер нь бол нийтлэг байдлаараа Монгол улсын хүүхэд багачууд ийм л зүйл хүсэж байна гэж ойлгож байна. Өөрөөр хэлэх юм бол тэдгээрийн оролцоог хангах, яг тэд хүүхэд, багачуудын сэтгэлгээ, сэтгэхүйгээр бас асуудалд хандах асуудлыг хөндөөд байна шүү дээ.

1 дүгээрт, тэр аймгийн Засаг даргын ажлыг үнэлэх тэр ажил дээр бол байгаль орчны асуудал, энэ хүүхдийн эрхийг хэрхэн орон нутгийн түвшиндээ хамгаалж байгаа асуудлыг ч гэдэг юм уу ийм тодорхой үзүүлэлт дээр л явмаар

байна. Ажлын байр бий болгосон ч гэдэг юм уу. Энэний хамгийн гол шалгуур нь магадгүй хүүхэд хамгааллын асуудал байж магадгүй. Түүнээс биш аймгуудын ажлыг чинь яаж дүгнээд байдгийг ч мэддэггүй шүү дээ шүү дээ.

Тийм учраас энэ рүү нэг гол фокуслаад яваад орон нутгийн түвшинд хүүхэд хамгааллын асуудал, хүүхдийн хөгжлийн асуудлыг бол бидний асуудал аа гэдэг маш том мэдрэмжийг, зохион байгуулалтыг энийгээ дагаад хийдэг байх хэрэгтэй байна. Төсөв мөнгөө тавьдаг байх хэрэгтэй байна. Ингэж байж бас энэ сум орон нутгийн ч хандлага, соёл өөрчлөгдөнө гэдгээ бас бодож энэ чиглэл рүү бас хүүхдүүдийн гаргаж байгаа саналыг бол 100 хувь дэмжиж байна. Энийг бол бид нар бас Хүний эрхийн дэд хорооноос бас ингээд зөвлөмж өгөөд явчхаж бас болж байна. Засгийн газарт чиглэл өгөх байдлаар.

2 дугаарт, хүүхдүүдийн хэлээд байгаа юм нь чөлөөт цагаа өнгөрөөх, хичээлээс гадуурх байдлаар өөрийгөө хөгжүүлэх тэр нөхцөл байдал дутмаг байна аа гэдэг зүйлийг маш олон ярьсан байна шүү дээ. Тэгэхээр бид хэд ийм хүүхдийн зарим юмнуудыг нэлээн бодолцож улс төржихгүйгээр нь шийдэх ёстой. 2-хон жилийн өмнө санаж байна хүүхдийн нөгөө ваучер буюу соёлын ваучерыг бүгдийг нь ингээд улс төржүүлсээр байгаад л хассан. Яг үнэндээ хэлэхэд 18 тэрбум төгрөг л байсан.

Одоо ингээд бас гишүүд бас Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль, Нийгмийн ажилтны тухай хууль, Мөнхсайхан гишүүн жишээ нь Сургуулийн орчны аюулгүй байдлын тухай хууль ч гэдэг юм уу ингээд маш олон хуулиудыг ингээд зэрэгцүүлээд жоохон салангид уялдаагүй байдлаар л маш олон зүйлүүд явчих гээд байна шүү.

Дээрээс нь Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль Засгийн газраас орж ирэх гэж байна. Тэгэхээр энэ бодлогын бичиг баримтуудыг бас батлахдаа бид хэд бас нэгдсэн нэг ийм долгион дээр байж байж батлаад уялдаатай явахгүй бол ийм хуулиудыг хэлэлцэх явцад ийм тусдаа салангид уялдаагүй ийм бүтцүүд угсрагдчихдаг. Энэ нь өөрөө төсөв мөнгө нь бас их шаардаад ирнэ. Тэгээд хаана ч үгүй нөгөө хамар ч үгүй гэдэг шиг л ийм юм болчих вий. Тэгэхээр энэ рүүгээ бас нэг жоохон анхаарах юм руугаа оръё. Тэгээд тэр хүүхдийн оролцоотой тэр орчны аюулгүй байдлыг хангах энэ тэр дээр бол 100 хувь баймаар байна. Зөндөө бид нар жишээнүүд байна шүү дээ тогонд цохиулж үхэж байлаа. Саяхан л Дорнод аймагт байна уу даа бас нүхэнд хүүхэд унасан байна тээ? Тодорхой амьтан аврах гэж байгаад хөөрхий усанд живсэн ийм тохиолдол бас гарлаа. Маш харамсалтай зүйл боллоо. Одоо ингээд энэ хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг юм уу энэ сургуулийн ойр орчим, ер нь зүгээр энэ оршин суух бүсэд ойртож ажил хийж байгаа энэ хүмүүсийн хөдөлмөрийн.../минут дуусав./

Х.Баасанжаргал: Нэмэлт 1 минут Сайнзориг гишүүнийг.

П.Сайнзориг: Талбайдаа биш яг тэр орчны буюу тэрүүгээр зорчиж өнгөрч байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хангах чиглэлдээ мэдрэмжтэй ажилламаар байна. Одоо энэ барилгын кран эргээд л явж байгаа байхгүй юу. Тэгээд яг үнэндээ хэлэхэд энэ сургуулийн хүүхдийн тарах, эсвэл эхлэх цагаар жишээ нь зогсож сурах хэрэгтэй байна. Сэлбэ хот Сэлбийнхэн бол тэгж байгаа юм байна лээ. Тэгээд энэ хотын төвөөр чинь ийм аймшигтай байгаа байхгүй юу. Хүүхдүүд ерөөсөө л ийм эрсдэлтэй.

Тэгээд би тэр нохой, муурын асуудлыг бол санал нэг байна аа. Энийг ер нь зүгээр орон нутаг сайн анхаарах ёстой. Би бас Зөрчлийн хуулийн шинэчилсэн найруулгыг хийж байхдаа яг суурьшлын бүсэд тэжээж болох, болохгүй нохойны асуудлыг орон нутаг нь шийддэг байдлаар оруулсан юм. Ер нь бол тийм ажлын нохой гэдэг төрлийн нохойнуудыг бол оршин суух бүсэд бол тэжээдэггүй юм байна лээ. Тэжээж байгаа тохиол тодорхой маш шалгууртай бөгөөд тэр аюулгүй байдлыг хангасан тийм зүйлүүдээ байхгүй бол наадах чинь бол ингээд хүүхдүүдийг барьдаг, ноцдог. Нохойд бариулж хүүхэд хүртэл эндэж байсан тохиолдол байгаа шүү дээ. Тэр нь Кавказ овчарк байсан шиг санаж байна.

Х.Баасанжаргал: Тэгье нөгөө Гэрийн тэжээмэл амьтны тухай хууль батлагдсан. Хамгийн гол нь тэр хуулийн агуулга нь бол юу вэ гэвэл тухайн орон нутгийн удирдлагууд яг өөрийнхөө орон нутаг дээр байгаа гэрийн тэжээмэл амьтад, тэр дундаа нохой, муурын асуудлыг орон нутгийнхаа онцлогт тулгуурлаад шийдвэрлэх, бас тэр чинь нөгөө тодорхой үе шаттайгаар хэрэгжих хууль байгаад байгаа шүү дээ. Тодорхой хугацааны дараа бол гэрийн эдгээр амьтдын үржлийн асуудлыг илүү шинжлэх ухаанч, илүү анагаах суурьтай байдлаар бол энэ үржлийн асуудлыг нь шийдвэрлэх ийм хууль байгаад байгаа.

Тэгээд орон нутгуудаар явж байхад энэ хуулийг бол ер нь хэрэгжилт бол тун хангалтгүй байна уу даа гээд зүгээр одоогоороо ажиглагдаж байгаа. Ерөөсөө тийм бэлтгэл ажил ер нь хийхгүй байх шиг байна. Дээрээс нь иргэд бас энэ талаарх мэдээлэл маш муу байна. Иргэдэд бас энэ талаарх мэдлэг, мэдээллийг өгөх хэрэгтэй байна. Сая тэр хүүхэд сая саналаа гаргаж байна. Зүгээр хүүхдийн хичээл тарах, явах цагаар нохойгоо уячихдаг байгаач ээ л гэж байгаа байхгүй юу. Хамгийн энгийн.

Тэгээд хүүхдүүдийн хэлж байгаа санал хамгийн гол нь аягүй шийдвэрлэгдэж болохуйц, аягүй энгийн санал хүүхэд дүүд хэлж байгаа байхгүй юу. Бүх гудамжинд гэрэл тавь гэж хэлэхгүй байгаа юм. Хүүхдүүд том, өндөр газраа нэг том гэрэл тавьчааач ээ тэгээд болчихно оо гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр ингэж нөгөө хүүхдүүдээ өөрсдөө санал хэлэхээс гадна хүүхдүүдээс аягүй бүтээлч шийдлүүд гарч байна. Тэгэхээр тэрийг нь бас бид нар аягүй сайн сонсдог байх нь өөрөө эргээд үр дүнтэй байх ёстой юм болов уу гэж бодож байгаа. Тэгээд ялт ч үгүй энэ гэрийн тэжээмэл амьтны асуудлаар манай Хүний эрхийн дэд хороо хэдүүлээ бас нэг ярилцаж байгаад нэг энэ зохион байгуулалтыг хангаад ялангуяа аймаг, орон нутгийн удирдлагуудад энэ асуудлаар нэг чиглэл хүргүүлэх тийм ажлыг хийх нь ер нь зөв байх аа гэж бодож байгаа юм.

Сайнзориг гишүүний микрофоныг 1 минут.

П.Сайнзориг: Наадхыг чинь дэмжиж байна. Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль яах вэ батлагдаад жоохон хэрэгжилт тааруухан байна. Тэгэхээр энийг зүгээр яах вэ тодорхой хэмжээнд бас орон нутаг тэр зохицуулалтыг хийдэг байдлаа бас тодорхой бүсчлээд хийдэг байж болно. Ялангуяа нийтийн зориулалттай орон сууц болоод яг хүн амын төвлөрөл их бүхий юман дээр бол ажлын төрлийн нохойг бол тэжээхийг хориглочихмоор байгаа юм. Тэр Кавказ овчарк ч юм уу энэ бол бараг эзэн нь ч дийлэхээргүй том том нохойнууд байдаг байхгүй юу. Тэгээд тэр бол энэ аж ахуйн хашаа энэ тэрдээ л байж байх ёстой. Тэр хөдөө мал ахуйгаа хамгаалах юун дээр.

Тэгэхээр энэ бол ерөөсөө бид нар бас нэг аймаг аймгаар нь энэ нохойд, муурт хазуулж байгаа хүүхдүүдийн энэ асуудлыг бас нэг үзээд жижиг юм шиг мөртөө энэ бол бас хүүхдийн нөгөө сэтгэлийг гэмтээчихдэг их тэгээд орчиндоо бас ингээд айж ичдэг болдог ийм зүйл байдаг аа. Энийг бас анхааръя.

Тэгээд тэр сургуулиас гэр хүртэлх тэр гэрэлтүүлэг, зам харгуйг янзалъя гэдэг дээр бол үнэхээр зөв байна. Томчууд даанч алхаж үздэггүй учраас энэ явган замыг эсэргүүцээд байгаа байхгүй юу. Хүүхдүүд алхдаг, хөгшид алхдаг, хөгжлийн бэрхшээлтэй явдаг хүмүүс энэ хүмүүс.../минут дуусав./

Х.Баасанжаргал: “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Хүний эрхийн дэд хорооноос гарсан холбогдох санал, дүгнэлттэй холбоотой гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэсэн энэ саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье.

Санал хураалт явуулъя. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Хүний эрхийн дэд хорооноос гарсан холбогдох санал, дүгнэлтийг тусгуулах талаар Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтыг эхлүүлье.

Санал хураалтын дүнг танилцуулъя. Зөвшөөрсөн 5, 83.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Санал хураалтын дүнг.

Хүний эрхийн дэд хорооны санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Баасанжаргал танилцуулна.

Эхний хэлэлцэх асуудлыг дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

12.57 цаг

2 дахь асуудал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид ажилласан талаарх танилцуулгыг та бүхэнд хүргүүлье, танилцуулъя.

Цагдан хорих 461 дүгээр хорих анги дээр ажилласантай холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн Сангишаравын Дондов гишүүн өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Хорих 461 дүгээр ангид очиж ажилласан талаарх танилцуулга, мэдээллийг би та бүхэндээ хүргэе. Энэ санал хураалтгүй. Тэгье. Энэ дээр харин ийм 2, 3 нэгтгэн дүгнэлт байгаа. Энэ дээр харин хэдүүлээ нэг ярилцах ёстой юмнууд байгаа шүү. Санал хураалт бол байхгүй байгаа.

Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны дарга, хүний эрхийн гишүүд 2026 оны 05 сарын 21-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангид ажиллаж, цагдан

хорих үйл ажиллагаанд хүний эрхийн ажиллагааг хангаж буй байдалтай газар дээр нь танилцлаа.

Neguin.mn сайтын сэтгүүлч, эрхлэгч Баяржаргал нь цагдан хоригдож байх хугацаандаа өлсгөлөн зарлаж, уг өлсгөлөн 120 цаг үргэлжилсэн гэх мэдээлэлтэй холбогдуулан үүссэн нөхцөл байдалтай танилцсан.

Өлсгөлөн эрх, хууль ёсны, ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзсэн этгээдээс гомдол, шаардлагаа илэрхийлэх зорилгоор хэрэглэдэг хамгийн хүнд хэлбэрийн эсэргүүцлийн арга хэрэгсэл учраас хүний эрхийн талаасаа онцгой анхаарах ёстой асуудал зүй ёсоор ордог.

Сэтгүүл Баяржаргалын хувьд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг авах зайлшгүй үндэслэл хангалттай нотлогдоогүй, тогтоогдоогүй гэж үздэг бөгөөд уг арга хэмжээг хэрэгжүүлэх явцад цагдаагийн алба хаагчдын зүгээс хүнлэг бус харьцсан, цагдан хорих асуудлыг хэлэлцэн шүүх хуралдааныг нээлттэй явуулах шаардлагатай байсан гэдэг санал, хүсэлт, гомдлыг бол илэрхийлдэг. Түүнчлэн түүний эрүүл мэндийн байдал Цагдан хорих 461 дүгээр ангийн зүгээс эмнэлгийн хяналтыг тогтмол тавьж байгаа талаар холбогдох мэдээллийг авч бид нар танилцсан.

Хүний эрхийн дэд хорооны гишүүд тус ангид ажиллах үеэр дараах асуудлыг бас онцолж танилцсан.

1 дүгээрт, цагдан хорьж буй иргэний өлсгөлөн зарласан үйлдэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн эсэх, өлсгөлөн зарласан шийдвэр нь хорих байгууллагын дотоод журмын дагуу бүртгэгдсэн хяналттай хяналт явж байгаа эсэх, өлсгөлөн зарласан хүний эрүүл, мэнд аюулгүй байдалд шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдал, цагдан хоригдож буй нөхцөл, хүний эрхийн баталгааг хангаж байгаа эсэх, өмгөөлөгчтэй уулзах, гэр бүлтэйгээ холбоо тогтоох эрхийн хэрэгжилтийн талаар ангийн захирагч болон Хүний эрхийн Үндэсний Комиссын холбогдох албан тушаалтан болон цагдан хоригдож буй иргэнтэй биечлэн уулзаж бол тус тус тодруулсан.

Ингээд энэ уулзалтын явцад нэг дараах 4 асуудал дээр бид нар бас цаашид анхаарах хэрэгтэй байна аа гэдэг ийм зүйлийг та бүхэндээ танилцуулъя. Өнөөдөр санал хураахгүй ч гэсэн хэдүүлээ энэ асуудлаар бас эргэж зайлшгүй Хууль зүйн байнгын хороотойгоо ярих хэрэгтэй болох байх гэж бодож байгаа.

1 дүгээрт, энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын талаар олон нийтэд мэдээлэл хүргэхдээ хүний нэр төр, алдар хүнд, эрхэм чанарыг нь хүн хүндэтгэх, хуульд заасан хязгаарлалтыг мөрдүүлэх чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам шаардлагатай арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байна аа гээд.

Тухайлбал, яг бид нарын энэ уулзсан сэтгүүлч Баяржаргалын жишээн дээр бол цагдаагийн байгууллага олон нийтэд мэдээлэл хийхдээ гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон гэдэг байдлаар бол мэдээлэл хийсэн нь хүний нэр төр, алдар хүнд, эрхэм чанарыг бол бид нар үгүйсгэсэн, сөрөг нөлөө үзүүлэхүйц ийм үйлдэл гаргасан гэж үзэж байгаа. Тэгээд бид нар бас өөр олон жишээн дээр энийг мэддэг. Тийм учраас цаашид цагдаагийн байгууллага Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөл зэрэг ингээд хууль хяналтын байгууллагуудын зүгээс Авлигатай

тэмцэх газар ч гэсэн мөн адил энэ шалгагдаж байгаа хүний нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандаж ямар хязгаарлалтын хүрээнд энэ олон нийтэд мэдээллийг хийдэг байх юм бэ гэдэг энэ дүрэм, журмаа тодорхой болгож ирүүлэх, ажиллах хэрэгтэй байна аа гэж үзлээ.

2 дугаарт, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа эрхээ хязгаарлаж буй иргэнд энэ талаар нь хангалттай үндэслэлтэй тайлбарлаж, мэдээлэлтэй шийдвэр гаргах эрхээр нь бүрэн хангах хэрэгцээ шаардлага байна. Яагаад цагдан хоригдож байгаа юм, ямар үндэслэл байгаа юм, ямар үндэслэлээр өөрөө үгүйсгээд байгаа юм иргэн, тэр нь яагаад нотлогдохгүй байгаа юм бэ гэдэг талаар иргэнд маш тодорхой үндэслэлтэй, хангалттай бас мэдээллийг хүргэдэг байх хэрэгтэй байна.

3 дугаарт, ар гэрийн уулзалтын зөвшөөрлийг өгч буй байдалд дүн шинжилгээ хийж, уулзалтыг үндэслэлгүйгээр хязгаарлах замаар эрхээ хязгаарлуулсан хүнийг аливаа дарамтад оруулахгүй байх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтуудыг шаардлагатай бол өөрчлөлт оруулах хэрэгтэй байна.

Иргэн Баяржаргалын хувьд 04 сарын 10-наас хойш цагдан хоригдож байгаад бид нарыг очихын өмнөх өдөр буюу 05 дугаар сард 1 эргэлт, 4 сарын 26-нд 1 ар гэрийн эргэлт авсан гэдэг ийм мэдээллийг өгсөн. Тэгэхээр ер нь энэ ганцхан энэ иргэн Баяржаргал дээр биш өөр олон гэмт хэрэг, зөрчил дээр шалгагдаж байгаа хүмүүсийн хувьд ялангуяа цагдан хоригдож байгаа хүмүүсийн хувьд ар гэрийн уулзалтыг нь үндэслэлгүйгээр хязгаарладаг энэ талаарх мэдээллийг бол ар гэрт нь хангалттай өгдөггүй ийм байдал бол бас нэлээн түгээмэл байдаг. Тийм учраас энэ ар гэрийн уулзалтын зөвшөөрлийг ер нь бид нар нэг эргэж харах хэрэгтэй байна аа гэж үзэж байна.

Хамгийн сүүлд хорих ангийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар дүрэм журмыг сайтар танилцуулах, нээлттэй ил тод болгох, өлсгөлөн зарласан үед үзлэг, хяналт тавьж байгаа эмчтэйгээ итгэлцлийн харилцаа үүсгэх ийм нөхцөлийг бол бүрдүүлж ажиллах шаардлагатай байна аа гэж үзэж байна.

Иймд Хүний эрхийн дэд хороо цаашид холбогдох байгууллагуудаас нэмэлт мэдээллийг албан ёсоор гаргуулан авах, тухайн асуудал хүний эрх зөрчигдсөн эсэхэд дүн шинжилгээ хийж шаардлагатай тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулах, санал, дүгнэлт боловсруулах, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний хэрэглээг хүний эрхийн стандарт, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх чиглэлээр санал боловсруулах зэрэг арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа гэсэн ийм мэдээлэл байна.

Ингээд танилцуулсан мэдээлэлтэй холбоотой үг хэлэх, асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Соронзонболд гишүүнээр тасалбар болголоо. Баярбаатар гишүүний микрофоныг нээе.

Б.Баярбаатар: Дэд хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ. Эхний асуудал дээр бас хоцорчихсон. Сая бас бүлгийн хурал дээр энэ Хүүхдийн

хөгжлийн тухай хууль анхдагч хуулийн төсөл орж ирсэн. Энэтэй бас хүүхдийн эрхтэй холбоотой асуудал өргөн хүрээгээр нь бас яригдах зүйлүүд байгаа юм байна аа гэдгийг бас Хүний эрхийн дэд хороон дарга та бас анхаарал хандуулаад энэ хуулийг сайжруулах тал дээр бас олон зүйлүүд байна аа гэдгийг хэлэх нь зөв байх. Ерөнхий агуулгаар ер нь хүүхдийн хүмүүжил, энэ ёс суртахуун, төлөвшил гээд олон зүйлүүд дээр бол төвлөрөх ёстой асуудлууд байгаа юм байна гэж харж байгаа.

Энэ 461 дүгээр ангид ажиллаад ирсэн Дэд хороон дарга, зарим хүмүүстэй хамт тэгээд ер нь энэ 461 чинь урьдчилан хорих тээ? Тэнд хэн ч гэсэн гэм буруутай нь эцэслэн тогтоогдоогүй. Гэтэл тэнд ингээд хүний эрхийн зөрчил өргөн агуулгаараа явагдаад байдаг. Ер нь бид нар энэ таслан сэргийлэх арга хэмжээг ер нь яаж авдаг байх ёстой юм гэдэг. Би жишээлбэл өчигдөр нэг юм, нэвтрүүлэг үзээд бас нэг юм олж уншлаа л даа. Тэн дээр жишээлбэл өнгөрсөн жил Солонгост болсон хэрэг л дээ. Алдартай кино найруулагч нэг хоолны газар 3, 4 залуучуудад, бүлэглэлд зодуулаад амиа алдсан. Тархины үхэлтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хажууд нь хараад зогсож байсан. Бүтэн камерын бичлэг байна. Зодож байгаа, чирч гулдчаад ингэж байгаа.

Гэтэл тэр хэргийн холбогдогч 2 хүнийг нь хангалттай нотлох баримт байхгүй гээд гадуур байцгаагаад яваад байгаа байхгүй юу. Тэр бичлэг өөрөө хангалттай нотлох баримт байж болохгүй байна уу эс үгүй бол ямар агуулга байна? Тэгээд тэр хүн бол тархины үхэлтэй учраас 4 хүнд эрхтнээ шилжүүлээд 4 хүнд амьдрал бэлэглээд ингээд бурхны оронд одсон байна л даа. Гэтэл манайд эсрэгээрээ.

Би саяын түвшинд байдаггүй юм аа гэхэд энэ үнэхээр энэ таслан сэргийлэх арга хэмжээг нэг үзэмжээрээ хандаад байдаг юм биш биз дээ гэдэг асуудал. Одоо тэр дотор ганцхан сая 1 сэтгүүлчийн талаар л, өлсгөлөн зарласан сэтгүүлчидтэй холбоотой асуудлыг ярьж байна. Гэтэл тэнд чинь ингээд тодорхой нэг хөнгөн гэмт хэрэг үйлдээд ч юм уу, хулгайн гэмт хэрэг үйлдээд ингээд хоригдож байгаа залуучууд би бас олон байдаг гэж сонссон байхгүй юу. Гадуур ингээд байцаалт өгчих боломжтой ийм залуучууд олон байдаг аа л гэж.

Гэтэл энэ дээр бид нар ер нь энэ хууль, эрх зүйн орчныг нь цогцоор нь хараад энэ дэвшилтэт арга хэмжээ авахгүй бол ер нь бид энэ өнөөдрийн бид нарын энэ амьдарч байгаа нийгэмдээ энэ таслан сэргийлэх арга хэмжээ чинь нэг л эсрэгээрээ зохицохгүй байна уу даа л гэж л би хувь хүнийхээ хувьд дүгнээд байгаа. Тэгээд ийм санал байна. Тэгээд бас Дэд хорооны дарга энэ дээр цаашдаа анхаарч, тодорхой хуулийн төслүүдийг бол өөрчлөлтүүдийг оруулж ирэх нь зөв юм болов уу л гэсэн ийм саналтай байна.

Х.Баасанжаргал: Саналыг хүлээж авлаа. Тэгээд бид нар 4 хорих 461 дүгээр хорих ангид, одоо чинь 5 дугаар сар гэсэн үг шүү дээ. 5 дугаар сард ажиллаж байхад одоогийн байдлаар 1000 гаруй хүн тэнд цагдан хоригдож байгаа. Өмнөх оны ачаалалтайгаа даруй 20-30 хувь илүү гарсан. Гэсэн хэр нь өмнөх оны төсөв нь дахиад 20 хувь буурчихсан ийм байдалтай байгаа юм билээ.

Сүүлийн үед бас хар тамхины гэдэг ийм хэргээр маш олон энэ хар тамхи хэрэглэсэн хүмүүсийг маш олноор нь цагдан хорьж байгаа ийм зүйл бол нэлээн нэмэгдэх хандлагатай байна аа гэдэг ийм мэдээллийг өгсөн.

Мөн 461 дүгээр хорих ангид яг өнөөдрийн байдлаар 27 хүүхэд, насанд хүрээгүй хүүхэд мөн цагдан хоригдож байна лээ. Хоригдож байгаа байдалтай танилцсан. Тэгэхээр энэ мэт ингээд үзэхлээр бид нар яг зайлшгүй цагдан хорих шаардлагатай хүмүүсээ хорьж байна уу? Яг ямар үндэслэл вэ гээд ингээд асуудал бас нэлээн байхыг бол үгүйсгэхгүй. Гэхдээ үүнийг бол бид нар бас нэгдсэн байдлаар судалгаа, дүн шинжилгээ хийж байж нэлээн системтэй үзэх хэрэгтэй.

Хамгийн гол нь тэнд цагдан хоригдож байгаа хүмүүсийн ар гэрийнх нь уулзалт, цагдан хоригдож байгаа нөхцөл байдал, тэр дундаа ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд бол биологийн онцлогтой холбоотой ариун цэврийн байгууламж, хувцас солих гэх мэтээр ингээд ийм ийм эрүүл мэндийн үйлчилгээ хүртэл бас эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үйлчилгээнүүд бас өөр байдаг. Тэгэхээр яг энэ хүйсийн ийм онцлог ялгаатай байдалд суурилсан байдлаар бас энэ цагдан хорих байр маань өөрөө зохион байгуулалтад явж байна уу үгүй юу гэдэг дээр бас жаахан асуудлууд байгаа. Тэгээд цаашид бол дэд хороо анхаарч ажиллана аа гэж хэлье.

Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Надад ийм асуулт байгаад байгаа юм. Манай Хүний эрхийн дэд хороо маань энэ яг сэтгүүлчидтэй холбоотой асуудал үүссэн болоод очсон уу 1 дүгээрт? 2 дугаарт эсвэл өлсгөлөн зарласан гэдэг утгаар нь очсон уу гэдэг ийм асуулт байгаад байгаа юм. Яагаад гэхээр мэдээж ингээд хэргүүд бол олон төрөлтэй байгаа шүү дээ. Тэгэнгүүт бид нар зөвхөн сэтгүүлчтэй холбоотой ч юм уу, эсвэл өлсгөлөн зарласан гэдэг утгаар нь очоод байна уу гэдэг дээр нэг асуулт байгаад байна.

Ер нь бол ингээд тодорхой жишээлбэл давтамжтайгаар түрүүн бас хэн Баярбаатар гишүүн ярьж байна л даа ингээд цаана нь болохоор 464 ангид чинь хоригдож байгаа хүмүүс чинь маш олон хэргийн төрлөөс хамаараад хоригдож байгаа байх. Ингэнгүүт зарим нэг нь жишээлбэл жил хоригдож байдаг юм уу, зарим нь 10 хоног хүргэж байдаг юм уу, зарим нь хэд хоног хүргэдэг юм ийм статистик мэдээллүүд нь хэр гардаг юм байгаа юм. Тэгээд тэр мэрэн дээр нь сайн шинжилгээ хийж байгаад тодорхой хугацааны давтамжтайгаар эд нар очиж мэдээлэлтэй нь шалгадаг, танилцдаг, иймэрхүү байх тал дээр бас анхаарах ёстой юм болов уу л гэж.

Тэгэхгүй юу гэдэг юм нэг вэбсайт дээр гарсан мэдээлэл дээр үндэслээд л энэ бол ийм асуудал учраас гэдэг дээр нь ач холбогдол өгч ингэж очиж байна уу гэдэг нэг иймэрхүү бас асуудал тодорхойлох хэрэгтэй болов уу л гэж бодоод байна л даа. Тэгэхээр энэ дээр нэг ас хариулт авчихъя.

Х.Баасанжаргал: Энэ удаагийн энэ хорих 461 дүгээр ангид очиж ажилласан гол шалтгаан бол өлсгөлөн зарласантай холбоотой. Өлсгөлөн зарлаад 120 цаг гэдэг энэ цаг бол өөрөө бас нэг бага үе биш цаг. Тэгээд үүнтэй холбоотой гарч байгаа мэдээлэлтэй холбоотой бид нар очиж ажилласан. Энэ бол хүний эрхийн нэлээн бас өөрийнхөө эрхийг хамгаалж байгаа нэлээн хурц хэлбэрийн тэмцэл гэдэг ийм ангилалдаа ордог учраас бас үүн дээр бол хүний эрхийн байгууллагууд бол онцгой анхаарч ажиллах ёстой байдаг. Яг үүнтэй холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссоос өдөр болгон бас холбогдох албан тушаалтнууд нь гарч ажиллаад иргэн Баяржаргалын бас хүний эрхийн хяналтыг бол тухай бүрд нь бол тавиад ажилласан байгаа.

Ер нь бол бол бид нар цаашид яг энэ эмэгтэйчүүдийн хорих анги, хүүхдийн хорих анги, цагдан хорих 461 гээд эдгээр хорих ангиуд дээр үе шаттайгаар ажиллахаар Хүний эрхийн дэд хорооны төлөвлөгөө гарсан байгаа. Та бүхэн маань төлөвлөгөөгөө бас авсан байх. Тэгээд бид нар ирэх 7 хоногт амжаад Эмэгтэйчүүдийн хорих анги дээр очиж ажиллая гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Та бүхэнд холбогдох мэдээллийг хүргүүлнэ.

Ингэж ажилласны үр дүн нь өөрөө яаж гарах вэ гэвэл Засгийн газраас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг, шинэчилсэн найруулгыг өргөн барьж өгөх өргөн барих гэж байгаа. Тэгэхээр бид нар яг энэ онцлог энэ эмэгтэйчүүд, хүүхдүүдийн хүүхдийн хорих ч гэдэг юм уу, яг энэ урьдчилсан хорих, цагдан сэргийлэх арга хэмжээнүүд ч гэдэг юм уу эдгээр асуудлууд дээр яг Хүний эрхийн дэд хороо анхаарч, энэ стандартуудыг сайжруулах илүү өндөр хүний эрхийн хангалтыг, хүний эрхийг илүү өндөр түвшинд хангах энэ бодлогын ажлыг бол манай Хүний эрхийн дэд хороо хийх ёстой гэж харж байгаа.

Тийм учраас бас эдгээр хорих ангиуд дээр бас үе шаттай ажиллах ийм төлөвлөгөө гарсан байгаа.

Ингээд танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Танилцуулгыг хэлэлцэж дууслаа. Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүдтэй хүрэлцэн ирсэнд маш их баярлалаа.

13.11 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР